



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/762

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зөвлөгөөний арга хэмжээг тохиолдуулан эрхэлсэн ажил үйлсээрээ хамт олноо манлайлан ажиллаж буй Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэгийн бүлгийн багш Б.Баярмаа, 11 дүгээр цэцэрлэгийн арга зүйч Т.Чимгээ, 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Оюунчимэг нарыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг /Ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Б.ДҮГЭРЖАВ



Zax A/762 Ch

02 03733

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 14-ний өдрийн
А/762 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Баярмаа	8 дугаар цэцэрлэгийн бүлгийн багш	30000
2	Т.Чимгээ	11 дүгээр цэцэрлэгийн арга зүйч	30000
3	Б.Оюунчимэг	13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч	30000
Дүн			90000

-оОо-

